

## ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 12 дахь дугаарыг Дэлхийн хүн амын өдөрт зориулан бэлтгэж, эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

2005 оны долдугаар сарын арван нэгний өдөр тэмдэглэх Дэлхийн хүн амын өдөр нь “Адил Тэгш Байдал” уриан дор явагдаж байгаа ба сэтгүүлийн тусгай булангаас энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

*Сэтгүүлийн “Судалгаа” хэсгээс Эхийн эндэгдлийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйл, Хүүхдийн ядуурал, түүнийг хэмжих нь, Орон сууцны зах зээлийн эрэлтийн судалгаа, Айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургууль завсардалтанд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ, Монгол эрэгтэйчүүдийн үргүйдэлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс зэрэг хүн амын нийгмийн асуудлыг хөндсөн сонирхолтой судалгааны ажлуудтай танилцах болно.*

Үндэсний судлаачдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ дугаарын “Сургалт” хэсэгт Нийгмийн судалгааны асуулгын хуудас боловсруулахад анхаарах зарим асуудлууд болон Статистикийн дунджийн философийн агуулгыг толилуулж байна.

Харин “Үзэл бодол” хэсгээс та бүхэн Хотын талаарх ойлголт, тодорхойлолтууд, Байгууллагын удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудлын талаар эрдэмтэн, судлаачийн санал, бодлыг уншаарай.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлж, манай дараагийн дугаарт өгүүлэл, шүүмж, хэлэлцүүлэг илгээж болно.

Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**